

ХАЛУУН УСНЫ БАРИЛГЫН АЖИЛ, ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИК ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

2023.11.11

Захиалагч: АЗДТГазар
Барилга захиалагчийн хяналт:
Аймгийн ГХБХБГазар
Зураг төсөл: “Баярмега” ХХК
Гүйцэтгэгч: “Юу Би Жи” ХХК
Гэрээний хугацаа:
2022.07.18 2023.12.01
Гэрээний дүн: 350,085,067



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай Аймгийн ЗДТГ-ын захиалгатай Сүмбэр сумын 2 дугаар багт баригдах Халуун усны барилгын ажлыг “Юу Би Жи” ХХК 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрөөс 2022 оны 9 дүгээр сарын 16-ний өдрийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж ажлаа эхэлсэн. Барилгын талбайд тус компанийн зөвлөх инженер н.Нямдаваа, захирал Х.Сонинхүү мэргэжилтэн болон туслах 8 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

2022 оны ажлын гүйцэтгэл: цутгамал төмөр бетон аяган суурийн ажил, туслах ханын доорхи цутгамал суурийн ажил бүрэн хийгдсэн бетон шал шалны дулаалга цэвэр бохир усны шугам $+0,00$ түвшинээс дооших угсралтын ажил хийгдээд байна. 1-р давхарын цутгамал төмөр бетон каркасын ажил хийгдэж дууссан.

Ажил гүйцэтгэх хугацаанд тулгарсан хүндрэлтэй асуудлууд:

- Гүйцэтгэгч байгууллагын санхүүгийн чадамж
- Барилгын материалын үнийн өсөлт
- Ажлын зургийн зөрүүтэй байдал, алдаа дутагдал /БА,ББ/
- Бетон зуурмагийн узель бетон нийлүүлэлт удаашралтай, дээрхи хүндрэлээс хамаарч ажил удааширч он дамжин хэрэгжих шалтгаан болсон.

Барилга захиалагчийн хяналтаас:

- Суурийн бетон бэлтгэлийн доорхи буурь хөрсийг давтан нягтруулсан
- Хэрэглээний халуун ус, цэвэр усны шугамын дулаалга хийлгэсэн,
- 1-р давхарын цутгамал төмөр бетон баганын арматурчлал зөрүүлэг дутуу хийсэн байсаныг нормын дагуу гүйцэтгүүлсэн.
- Бохир усны цэвэр усны гаргалгааг ажлын зурагт заасан түвшинээс дээр угсарсан байсаныг доошлуулж зургийн дагуу хийлгэсэн.

2023 оны ажлын гүйцэтгэл: Барилгын гадна өрлөгийн ажлыг 8 дугаар сарын 17-ны өдөр эхэлсэн гадна ханын бүтэц нь: ажлын зурагт 120мм өнгөлгөөний тоосго+100мм полистрол хавтан дулаалга +380мм ердийн улаан тоосгон хана гэсэн бүтэцтэй ажлын зургийн дагуу гадна ханын өрлөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Дотор хана 120,250мм ердийн улаан тоосгон хана төлөвлөсөн байсаныг зургийн дагуу хий гүйцэтгэв. Гадна дотор өргийн ажилд босоо түвшинд 600мм багананаас анкерлаж бэхэлгээ гаргасан өрлөгийн тор 380мм тавьж гадна дотор өрлөгийг холбож өгсөн.

Барилгын дээвэр: ажлын зураг БА-ББ зураг зөрүүтэй байсанаас шалтгаалж дээврийн зураг төслийн байгууллагаар дахин хийгдэж зургийн дагуу дулаалга усны хаялага хийгдээд байна. Ажлын зурагт дамнуруу тусдана дулаалж шавардлага хийж 2 үе хар цаас наахаар төлөвлөсөн дээврийн байгуулалтыг дамнуруу алсгалаал хооронд ус хаялага налууг гаргахаар төлөвлөсөний дагуу дулаалга бетоны ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Барилгын гадна цэвэр усны ажил эхэлсэн ф90,ф50мм хуванцар хоолойгоор эргэлттэй системээр цэвэр усаар хангахаар төлөвлөсөн дагуу дээрхи шугам хоолойг дулаалга, халдаг уян кабелийн хамт хийж угсралтын ажлыг гүйцэтгэж байна.

Гадна бохир: зураг төсөлд цутгамал төмөр бетон каркастай соруулдаг байдлаар 40м³ байгууламж төлөвлөсөн бол цаг хугацаа хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулж 40м³ металл савыг дулаалж хийж гүйцэтгэхээр гүйцэтгэгч байгууллага хүсэлт тавьсаны холбогдох байгууллагууд зөвшилцөөд хийж гүйцэтгэхээр шийдвэрлэсэн.

Барилгын гадна хаалга цонх суулгасан. 3 давхар шилтэй вакум цонх, төмөр хаалгыг суулгаад байна. Барилгын дотор засал шугам хоолой угсралтын ажил хийгдэж байна.

